УС ЦАГ УУР ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
С.ЭНХТҮВШИН ТАНАА

Олон Улсын Иргэний Нисэхийн
аудитад бэлтгэх тухай

Олон Улсын Иргэний Нисэхийн байгууллага (ИКАО) –гоос өөрийн гишүүн орнууддаа аюулгүй ажиллагааны аудит хийж байгаа бөгөөд тус аудит манай улсад 2010 оны 6 сард ирэхээр төлөвлөгдсөн байгаа билээ.

Аудит нь Чикагогийн Конвенцийн заалтууд, түүний Хавсралтуудад заагдсан стандарт, зөвлөмжүүдийн хэрэгжилтийг нягтлах замаар хийгдэх ба аудитын асуулт, асуулгуудыг гишүүн орнууддаа урьдчилан ирүүлсэн болно.

ИКАО -гийн аудитын бэлтгэл ажлыг хангах явцад нисэхийн цаг уурын үйл ажиллагаанд баримталж буй дүрэм журам, стандартуудыг конвенцийн Хавсралт 3-ын стандарт, зөвлөмжүүдэд нийцүүлэн шинэчлэн боловсруулах, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байна.

Үүний зэрэгцээ, нисэхийн цаг уурын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хүчин төгөлдөр дүрэм, журмуудыг цэгцлэх, тэдгээрт тусгагдсан зохицуулалтын давхардлыг арилгах, шаардлагагүй заримыг хүчингүй болгох зэргээр эрх зүйн эмх цэгц хийх нилээдгүй ажил байна.

Энэхүү аудит шалгалтын үнэлгээ нь аль нэгэн агентлаг, нэгж байгууллагынх биш харин тухайн гишүүн улсад өгөгдөх үнэлгээ байх тул аудитын бэлтгэл ажилд ач холбогдол өгч хамтран ажиллана гэдэгт найдаж байна.

Хувийг: НЦУТ-д,

ИКАО-ГИЙН АУДИТАД БЭЛТГЭХ АЖЛЫН
ХЭСГИЙН ДАРГА Д. БАТЧУЛУУН